



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 5 дугаар
сарын 29 өдөр

Дугаар А-98

Улаанбаатар
хот

Нийслэлийн нийтийн тээврийн бай-
гууллагуудад бүтцийн зарим өөрч-
лөлт хийх тухай

1. Улаанбаатар хотын Тээвэр зохицуулалтын газрыг 1997 оны 6 дугаар сарын 01-ний өдөрөөс байгуулж, тус газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Улаанбаатар хотын Тээврийн газрын даргын үүрэгт ажлаас Шагдар овогтой Дашгэрэнг чөлөөлж, Тээвэр зохицуулалтын газрын даргаар Намсрай овогтой Нямдавааг томилсугай.

3. Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийг үр дүнтэй ашиглах зорилгоор тус улсаас нийлүүлсэн хөдлөх бүрэлдэхүүн, засвар техникийн үйлчилгээний товийг нэгтгэн Автобус-1 компани болгон өөрчилсүгэй.

4. Япон улсын тусламжаар буй болсон автобусны засвар техникийн үйлчилгээний төв, автобусыг төрөлжүүлэн зохион байгуулж байгаатай холбогдуулан Автобус-3 компанийг Автобус-1 компанийн үлдсэн хөдлөх бүрэлдэхүүн, барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгөтэй нэглэж Автобус 3 компани болгон өөрчлөн зохион байгуулсугай.

5. Хотын Тээвэр зохицуулалтын газар (н.Нямдаваа)-г даалгах нь

а/ Зорчигч тээврийн компаниудын удирдлагын тухай саналаа боловсруулж энэ оны 6 дугаар сарын 05-ны дотор холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлсүгэй.

б/ Зорчигч тээврийн компаниудын зохион байгуулалт бүтцийн өөрчлөлтийг энэ оны 6 дугаар сарын 10-ны дотор хийж танилцуулах.

6. Энэ шийдвэр гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1991 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 86 дугаар тогтоолын 15 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

[Signature]

Ж.НАРАНЦАЦРАНТИ

Нийслэлийн Засаг Даргын 1997 оны
4-98 тоот захирамжийн хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ТЭЭВЭР ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН БҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Улаанбаатар хотын Тээвэр зохицуулалтын газар нь (цаашид газар гэнэ) нийслэлийн тээврийг хөгжүүлэх талаар Засгийн газрын болон Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, чиглэлд тусгагдсан бодлого чиглэлийг хэрэгжүүлэх, хотын нийтийн зорчигчдын тээврийн үйлчилгээнд хяналт тавьж зохицуулах үүрэг бүхий өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зөрчмөөр, хотын захирагчийн албаны харъяанд ажиллах байгууллага мөн.

2. Газрын зорилго нь нийслэлийн нийтийн зорчигчдын тээврийн үйлчилгээнд өмчийн болон хэвшлийн аж ахуйн нэгжүүд чөлөөтэй өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлсэн тээврийн үйлчилгээг бий болгох, түүний чанар, хүртээмжийг дээшлүүлэх бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд зохицуулах, зохих дэмжлэг үзүүлэхэд оршино.

3. Нийслэлийн засаг дарга нь тус газрын даргыг иргэний гэрээний үндсэн дээр ажилд томилж буюу ажлаас чөлөөлнө.

Дарга нь газрын зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хотын Засаг даргын өмнө хариуцаж тайлагнах бөгөөд эрх хэмжээнийхээ үүрээнд Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн тусгаал шийдвэр гаргана.

4. Газар нь банкны байгууллагад харилцах данстай, гадаад дотордын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй гэрээ хэлцэл байгуулан ажиллах хуулийн этгээд бөгөөд орлогоороо зардалаа нөхөх зөрчмөөр ажиллана.

Газрын орлого нь нийтийн тээврийн үйлчилгээнд оролцогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд гэрээний үндсэн дээр тээврийн үйлчилгээний бүртгэл хяналт, зохицуулалт хамсний хөлс болон бусад ажил үйлчилгээний орлогоос бүрдэнэ.

5. Газар нь тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хөрө. Газрын үүрэг

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн зорчигчдын тээврийн хэтийн болон ойрын хугацааны эрэлт хэрэгцээг судалсны үндсэн дээр тээврийн үйлчилгээний сүлжээ, төлөвлөлтийг боловсруулж түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан зохицуулах.

2. Нийслэлийн дотор нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн аж ахуйн нэгж иргэд чөлөөтэй өрсөлдөх орчин бүрдүүлэх, хэвийн хэвшлийн оролцоог өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн тээвэрлэлт гүйцэтгэх чадвар боломжийг тодорхой нөхцөл үзүүлэлтийн дагуу сонгон шалгаруулж тусгай зөвшөөрөл олгох ажлыг Нийслэлийн Засаг даргын эрх олгосны дагуу гүйцэтгэх.

3. Нийслэлийн нийтийн тээврийн автобус, троллейбус, таксийн тээврийн үйлчилгээний чиглэл, сүүлжээ, ажиллах график, цэгийн хуваарийг тогтоох, өөрчлөх, шинэчлэх санал боловсруулж шийдвэрлүүлэх.

4. Нийслэлийн дотор зорчигчдын нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тэдгээрийн тээврийн үйлчилгээний чанар, цагийн хуваарь, графикийн биелэлтэнд өдөр тутмын бүртгэл хяналт тавьж, шаархай зохицуулах үйлчилгээ үзүүлэх.

5. Зорчигчдын нийтийн тээврийн үйлчилгээний талаарх олон нийтийн санаа бодлыг судлах, зорчигчдын санал гомдлыг шаархай барагдуулахад дэмжлэг үзүүлэх.

6. Авто тээврийн талаар мөрдөж байгаа хуучь тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан Засаг даргын захирамж болон Тээвэр ашиглалтын дүрэм журам, үйлчилгээний стандарт, норм нормативын биелэлтийг хотын нутаг дэвсгэр дэхь тээвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шалгаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тэдгээрийг боловсронгуй болгох санал гаргах.

7. Нийслэлийн нийтийн зорчигчдын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санхүү эдийн засаг, үйл ажиллагааны мэдээ, тайланг нэгтгэн судалгаа дүгнэлт хийж тээврийн үйлчилгээг сайжруулах, хэрэглэгчдийн болон тээвэр эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах санал боловсруулж холбогдох дээд байгууллагад зохих журмын дагуу тавьж шийдвэрлүүлэх.

8. Нийслэлийн нийтийн зорчигчдын тээврийн хөгжлийн хэтийн төлөвийг судлан тодорхойлох, нийтийн тээврийн үйл ажиллагааны талаар бодлого боловсруулах шаардлагатай мэдээллийг бий болгож хотын удирдлагыг хангах, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд тээврийн мэдээ, мэдээллээр үйлчлэх.

9. Тээврийн ажил үйлчилгээ эрхлэгчдэд болон тээврээр үйлчлүүлэгч нэрт хэрэглэгдэх зөвшөөрөл, гэрчилгээ, үнэмлэх зэрэг бичиг баримт болон зорчигчдын тасалбар, байнгын билет зэрэг үнэт цаасыг нэгдсэн журмаар хэвлүүлж хангах, тэдгээрийн ашиглалт зарцуулалтанд хяналт тавих.

10. Хотын нийтийн зорчигчдын тээврийг хөгжүүлэхэд дотордын хөрөнгө орцулалт хийх болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн үндэслэл судалгаа гаргах, төсөл хэрэгжүүлэхэд оролцох.

11. Нийслэл хотын зорчигчдын нийтийн тээврийн зориулалттай хөдлөх бүрэлдэхүүний паркийн бүтцийг оновчтой болгох, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, техник ашиглалтын шаардлагад илүү нийцтэй, эдийн засгийн хэмнэлттэй тээврийн хэрэгслийг сонгож ашиглах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд Нийслэлийн Засаг даргад дэмжлэг үзүүлэх, аж ахуйн нэгж байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх.

12. Авто тээврийн хэрэгслийн улсын үзлэг тооллогыг хотын нутаг дэвсгэрт холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, нийтийн тээвэрт оролцож байгаа тээврийн хэрэгслийн техникийн болон тээвэр ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагын биелэлтэнд Нийслэл хотын удирдах байгууллага, тохируулагч агентлагийн удирдамж чиглэлийн дагуу техникийн хяналтыг хийх.

13. Тээврийн үйлчилгээнд дангаар ноёрхох явдлыг хязгаарлаж өрсөлдөөн өрнүүлэх замаар хотын нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифыг тогтвортой уян хатан байлгах бодлогыг хэрэгжүүлэх, үнэ тарифийн үндэслэл тооцоог хянаж хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах.

14. Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээний шатмал, чиглэл бүрээр орлого, зардалын тооцоог нарийвчлан хийж, нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэгчтэй гэрээ хийх, нийгмийн шаардлагаар зайлшгүй алдагдалтай ажиллах чиглэлийн алдагдлыг нөхөх асуудлыг боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын Газарт тавьж шийдвэрлүүлэх.

15. Нийслэл хотод орж гарч байгаа тээврийн хэрэгслийн ашиглалт, үйлчилгээний байдалд хяналт тавьж шалган бүртгэх товчоодын үйл ажиллагаанд мэргэжлийн түслэлцээ үзүүлэх, зохицуулалт хийх.

Гурав. Тээвэр зохицуулалтын газрын эрх

Хотын Тээвэр Зохицуулалтын газар нь Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд Нийслэлийн нутаг дэвсгэрт тээврийн бодлого-төлөвлөлтийг хэрэгжүүлэн зохицуулах үйл ажиллагаа эрхлэхдээ дараахь эрх эдэлнэ.

1. Газрын өмч хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомж, Басгийн газрын шийдвэр болон энэхүү дүрэмд нийцүүлэн эзэмшин ашиглаж, захиран зарцуулах.

2. Тээврийн ажил үйлчилгээ эрхлэгчдэд бүртгэл-хяналт, шалгалт эзүүлэлт, зөвшөөрөл олгох зэргээр ажил үйлчилгээ үзүүлснийхээ төлбөр, хураамжийг гэрээний дагуу авах.

3. Газрын хариуцах асуудлаар гадаад орны болон өөрийн улсын холбогдох байгууллагатай харилцах, Нийслэлийн Засаг даргын болон холбогдох эрх бүхий байгууллагын эрх олгосны дагуу гэрээ хэлцэл хийж, хамтран ажиллах.

4. Хотын дотор Нийтийн зорчигчдын тээврийн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх төсөл, хөтөлбөр, техник-эдийн засгийн үндэслэлд экспертиз хийж, санал дүгнэлтээ холбогдох байгууллагад тавих.

5. Нийслэлийн Засаг даргын эрх олгосноор нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний гэрээ, тусгай зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд түүнийг хүчингүй болгох.

6. Хотын нийтийн тээврийн үйлчилгээг хүн амд ойртуулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор үйлчилгээний чиглэлийг өөрчлөх, шинээр нээх, хаах талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх.

7. Газрын үйл ажиллагааны хүрээнд авто тээврийн ашиглалт, нийтийн тээврийн үйлчилгээний талаарх хууль тогтоомж, нийслэлийн удирдах байгууллагын захирамж, шийдвэрийн биелэлтийг хангуулах, зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулж, хохирлыг арилгуулах.